



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Г Гүйцэтгэх захирлын албан тушаалд Ү
томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Компанийн тухай хуулийн 84.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 10.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Соёмбо инвестмент корпораци” ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд Аюуш овогтой Амарбуянг томилохыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Соёмбо инвестмент корпораци” ХХК/А.Амарбуян/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар/Д.Нямцэрэн/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН